



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 07-өдөр

Дугаар А/585.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а" дахь заалт Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн гаднах, хашаа, хайс, биеийн тамирын талбайн тохижилтын ажил /Жаргалант сум, Буянт баг/-н ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

А.Жамъяансүрэн -Мэргэжлийн хяналтын газрын хэлтсийн дарга, Улсын ахлах байцаагч

Б.Түмэндэмбэрэл -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Төгөлдөр - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газрын хэлтсийн дарга

Х.Баярлах -Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: М.Баяржаргал -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Дээрх ажлыг зураг, төсөв, стандартын дагуу хуулийн хүрээнд гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН